

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1	Өглөгийн талаар	11
3.2	Түрээсийн барьцаа хөрөнгийн талаар	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрлөлтийн тайлан	15
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/214
танай _____ -ны № _____ -т

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Б.ГАНБАТ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2019\0224SAG3.Docx


370480

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Ганбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн барьцааны өглөгийн үлдэгдлийг холбогдох иргэн, аж ахуй нэгж байгууллагатай тооцоо нийлж, актаар баталгаажуулах, ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах, төрийн сан дах Барьцааны 100900008354 тоот түр дансанд байршуулсан хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 25-наас 2019 оны 2 дугаар сарын 4-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор О.Баярмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А-1/184 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь "Төрийн өмчийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, удирдлагыг сайжруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэн, ил тод өрсөлдөх тэгш боломжийг хангахад оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилго тодорхойлон ажиллажээ. Үүнд:

- Төрийн өмчийн талаарх хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах,
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, удирдлага зохион байгуулалтаар хангах,
- Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх,
- Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалттай холбоотой бүртгэл, тооллого явуулах,
- Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих,
- Төрийн өмчийн ашиглалтын үр өгөөжид мониторинг хийх,
- Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй зохион байгуулж мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулах.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acoulous” програм хангамж ашигладаг байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 14 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн

6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 70,373.5 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 14 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	322,297.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	1,171,317.6	
	Дүн	3	1,493,614.7	

2.8.1 Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 онд улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашиг 1,171,317.6 мянган төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн тул төлбөрийн акт тогтоосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д "Улсын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.5.1-д "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ... төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг" гэж заасантай нийцэхгүй, мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 322 дугаар тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 онд улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн ногдол ашгийн төлбөр нийт 1,171,317.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц чухал асуудал илрээгүй болно.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 10 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 84 арга хэмжээнд зориулан 2018 онд 2,358,887.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 2,242,440.9 мянган төгрөг буюу 95.1 хувьтай байгаа нь батлагдсан төсвийг 116,446.1 мянган төгрөг буюу 4.9 хувиар хэмнэсэн, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжиж дуусаагүй, нэмэлт санхүүжилтээр бэлтгэх техник, тоног төхөөрөмжийн зарцуулах эрхийг 2018.12.31-нд нээсэн тул худалдан авалт бүрэн хийгдээгүй болон дахин үнэлгээний зардлын хэмнэлт зэргээс шалтгаалжээ.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг авч үзвэл: 2018 оны төсвийн тухай хуулиар өмч хувьчлалын орлого 100,700,000.0 мянга, ногдол ашиг 27,000,000.0 мянга, нийт 127,773,600.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас ногдол ашиг 43,234,798.1 мянга, түрээсийн орлого 2,208,351.5 сая, өмч хувьчлалын орлого 708,904.5 мянга, бусад орлого 46,245.2 мянга, нийт 46,198,299.3 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөг 100,000,000.0 мянган төгрөгөөр тасалдуулсан нь “Төрийн өмчийг хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл батлагдаагүй учир төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй зарим хөрөнгийг борлуулах дуудлага худалдаа хийгдээгүйгээс шалтгаалсан байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгөгдсөнөөс 2018 оны жилийн эцсийн байдлаар биелэлтийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1 ӨГЛӨГИЙН ТАЛААР

Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гурвалсан гэрээний дагуу байршуулсан 535 түрээслэгчийн 988,039.5 мянган төгрөгийн түрээсийн барьцааны үлдэгдэлтэйгээс 2018.12.31-ны байдлаар 107 түрээслэгчийн 322,297.1 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Цаашид өглөгийн үлдэгдлийг холбогдох иргэн, аж ахуй нэгж байгууллагатай тооцоо нийлж, актаар баталгаажуулах.

3.2 ТҮРЭЭСИЙН БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ТАЛААР

Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагуудтай хийсэн гурвалсан гэрээний дагуу 2017 онд 876,374.4 мянга, 2018 онд 111,665.1 мянга, нийт 988,039.5 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг Төрийн сан дахь тус байгууллагын "түр" дансанд байршуулсан байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2016 оны 102 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар"-ын 3.3, 2018 оны 293 дугаар тогтоолоор "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-д оруулсан нэмэлт өөрчлөлтийн 6.14-т заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Зөвлөмж: Цаашид ТӨБЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллах, төрийн сан дахь Барьцааны 100900008354 тоот түр дансанд байршуулсан хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 5 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,173,050,326.00</u>	<u>988,839,526.12</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	886,446,707.00	988,839,526.12
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	800,000.00	800,000.00
31110	Төгрөг	800,000.00	800,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	885,646,707.00	988,039,526.12
3121	Төгрөг	885,646,707.00	988,039,526.12
31213	Арилжааны банк дахь харилцах	7,272,294.00	0.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	878,374,413.00	988,039,526.12
34	УРЬДЧИЛГАА	1,272,912,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,272,912,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,691,619.00	00.00
354	Хангамжийн материал	13,691,619.00	00.00
35410	Бичиг хэргийн материал	7,592,519.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	6,099,100.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>20,441,484,147.63</u>	<u>4,831,024,221.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	20,441,484,147.63	4,831,024,221.54
392	Биет хөрөнгө	20,441,484,147.63	3,523,141,821.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	21,078,402,084.00	3,026,142,380.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,025,815,227.20	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	360,565,343.40	774,244,249.40
39204	Хуримтлагдсан элэгдэл	-191,378,208.39	-424,220,345.92
39205	Машин тоног төхөөрөмж	418,986,398.92	334,329,761.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	-379,556,688.50	-329,426,913.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	394,576,367.20	381,166,217.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-214,295,921.80	-239,093,527.06
393	Биет бус хөрөнгө	00.00	1,307,882,400.00
39301	Програм хангамж	00.00	1,272,912,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	990,000.00	35,960,400.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-990,000.00	-990,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>22,614,534,473.63</u>	<u>5,819,863,747.66</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	885,646,707.00	988,039,526.12
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	885,646,707.00	988,039,526.12
413	Өглөг	885,646,707.00	988,039,526.12
4136	Бусад өглөг	885,646,707.00	988,039,526.12
41361	Байгууллагад төлөх өглөг	878,374,413.00	988,039,526.12
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7,272,294.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>21,728,887,766.63</u>	<u>4,831,824,221.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	21,728,887,766.63	4,831,824,221.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	35,655,560.00
51101	Өмч: - төрийн	00.00	35,655,560.00
512	Хуримтлагдсан үр дүн	21,728,887,766.63	4,398,102,126.59
51210	Өмнөх үеийн үр дүн	21,728,887,766.63	21,728,887,766.63
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-17,330,785,640.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	398,066,534.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>22,614,534,473.63</u>	<u>5,819,863,747.66</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,318,003,407.84	48,534,279,357.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,012,971,475.84	46,588,387,357.43
120	Нийтлэг татварын бус орлого	31,012,971,475.84	46,588,387,357.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	730,946,274.10	675,925,140.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,538,573.10	46,245,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	239,591,963.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	710,407,701.00	390,087,976.81
120005	Түрээсийн орлого	2,058,415,002.01	1,968,759,542.56
120006	Өмч хувьчлалын орлого	17,079,820,622.00	708,904,514.97
120007	Ногдол ашгийн орлого	11,143,789,577.73	43,234,798,159.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,305,031,932.00	1,945,892,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,303,735,900.00	1,945,892,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,303,735,900.00	1,945,892,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,296,032.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,296,032.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	32,260,396,184.95	48,779,588,851.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,260,396,184.95	48,779,588,851.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,916,636,032.11	2,627,003,617.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	777,417,300.00	789,519,000.00
210101	Үндсэн цалин	575,583,573.00	606,623,600.00
210102	Нэмэгдэл	147,928,227.00	127,989,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,905,500.00	53,905,500.00
210104	Урамшуулал	00.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,866,725.00	94,622,300.00
210201	Тэтгэврийн даатгал	69,092,525.00	63,081,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,943,400.00	7,885,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,554,900.00	6,308,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	388,800.00	1,577,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,887,100.00	15,770,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	10,520,330.00
210304	Байрны түрээс	00.00	10,520,330.00
2104	Хангамж, бараа материалын зардал	61,107,700.00	117,888,320.30
210401	Бичиг хэрэг	21,020,900.00	72,189,119.00
210402	Тээвэр, шатахуун	12,649,500.00	12,159,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,552,300.00	18,531,101.30
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,885,000.00	15,009,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,960,000.00	108,095,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	104,135,450.00
210604	Урсгал засвар	3,960,000.00	3,960,000.00
2107	Томилолт, зочны зардал	66,689,000.00	232,256,033.00
210701	Гадаад албан томилолт	00.00	155,741,892.00
210702	Дотоод албан томилолт	66,689,000.00	76,514,141.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,525,000.00	427,484,541.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,354,000.00	414,454,700.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	495,000.00	508,641.00
210803	Даатгалын үйлчилгээ	495,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	297,000.00	297,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21,800.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,812,700.00	10,652,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	49,500.00	49,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	660,070,307.11	846,617,642.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	184,187,055.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,884,190.00	40,724,736.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	658,186,117.11	621,705,851.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,343,760,152.84	46,152,585,233.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,632,500.00	243,562,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,732,500.00	127,512,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,900,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	116,050,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,315,127,652.84	45,909,022,733.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,315,127,652.84	45,909,022,733.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	57,607,222.89	-245,309,493.66
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	27,425,761.16	17,085,476,146.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	27,425,761.16	14,066,659,254.74
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	3,018,816,891.64
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-27,425,761.16	17,085,476,146.38
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	30,181,461.73	17,330,785,640.04

4.3 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			21,728,887,766.63	21,728,887,766.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Тайлант үеийн үр дүн				
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			21,728,887,766.63	21,728,887,766.63
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			21,728,887,766.63	21,728,887,766.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			21,728,887,766.63	21,728,887,766.63
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		398,066,534.95		398,066,534.95
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн	35,655,560.00		-17,330,785,640.04	-17,295,130,080.04
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	35,655,560.00	398,066,534.95	4,398,102,126.59	4,831,824,221.54

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>32,485,970,119.84</u>	<u>48,253,856,493.74</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,180,938,187.84	46,307,964,493.74
120	Нийтлэг татварын бус орлого	31,180,938,187.84	46,307,964,493.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,538,573.10	285,837,163.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	46,245,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,538,573.10	239,591,963.50
120005	Түрээсийн орлого	2,058,415,002.01	1,968,759,542.56
120006	Өмч хувьчлалын орлого	17,079,820,622.00	708,904,514.97
120007	Ногдол ашгийн орлого	11,143,789,577.73	43,234,798,159.59
120009	Бусад орлого	878,374,413.00	109,665,113.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,305,031,932.00	1,945,892,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,303,735,900.00	1,945,892,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,303,735,900.00	1,945,892,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,296,032.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,296,032.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>31,599,523,412.84</u>	<u>48,151,463,674.62</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,599,523,412.84	48,151,463,674.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,255,035,760.00	1,998,878,441.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	777,417,300.00	789,519,000.00
210101	Үндсэн цалин	575,583,573.00	606,623,600.00
210102	Нэмэгдэл	147,928,227.00	127,989,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	53,905,500.00	53,905,500.00
210104	Урамшуулал	00.00	1,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,866,725.00	94,622,300.00
210201	Тэтгэврийн даатгал	69,092,525.00	63,081,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,943,400.00	7,885,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,554,900.00	6,308,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	388,800.00	1,577,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,887,100.00	15,770,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	00.00	10,520,330.00
210304	Байрны түрээс	00.00	10,520,330.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,693,339.00	103,036,701.30
210401	Бичиг хэрэг	25,301,539.00	38,816,600.00
210402	Тээвэр, шатахуун	12,929,500.00	12,979,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,552,300.00	18,531,101.30
210404	Ном, хэвлэл	00.00	23,800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,910,000.00	8,910,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,960,000.00	108,095,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	104,135,450.00
210604	Урсгал засвар	3,960,000.00	3,960,000.00
2107	Томилолт, зочны зардал	59,416,706.00	239,528,327.00
210701	Гадаад албан томилолт	00.00	155,741,892.00
210702	Дотоод албан томилолт	59,416,706.00	83,786,435.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	270,525,000.00	428,644,541.29
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,354,000.00	414,454,700.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	495,000.00	508,641.00
210803	Даатгалын үйлчилгээ	495,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	297,000.00	297,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21,800.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,812,700.00	11,812,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	49,500.00	49,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,156,690.00	224,911,791.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	184,187,055.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,156,690.00	40,724,736.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,344,487,652.84	46,152,585,233.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,632,500.00	243,562,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,732,500.00	127,512,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,900,000.00	116,050,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,315,855,152.84	45,909,022,733.53
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,315,855,152.84	45,909,022,733.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>886,446,707.00</u>	<u>102,392,819.12</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	886,446,707.00	102,392,819.12
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	886,446,707.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	886,446,707.00	988,839,526.12

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		800,000.00		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,358,887,100.00	2,242,440,941.10	116,446,158.90	95.1
УРСГАЛ ЗАРДАЛ	2,358,887,100.00	2,242,440,941.10	116,446,158.90	95.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,115,324,600.00	1,998,878,441.10	116,446,158.90	94.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,519,000.00	789,519,000.00	-	100.0
Үндсэн цалин	606,623,600.00	606,623,600.00	-	100.0
Нэмэгдэл	127,989,900.00	127,989,900.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	53,905,500.00	53,905,500.00	-	100.0
Урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,622,300.00	94,622,300.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	63,081,500.00	63,081,500.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	7,885,200.00	7,885,200.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	6,308,100.00	6,308,100.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	1,577,100.00	1,577,100.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	15,770,400.00	15,770,400.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,420,330.00	10,520,330.00	6,900,000.00	60.4
Гэрэл, цахилгаан	2,900,000.00		2,900,000.00	-
Түлш, халаалт	2,000,000.00		2,000,000.00	-
Цэвэр, бохир ус	2,000,000.00		2,000,000.00	-
Байрны түрээс	10,520,330.00	10,520,330.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	103,042,400.00	103,036,701.30	5,698.70	100.0
Бичиг хэрэг	38,816,600.00	38,816,600.00	-	100.0
Тээвэр, шатахуун	12,929,500.00	12,979,000.00	- 49,500.00	100.4
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,586,300.00	18,531,101.30	55,198.70	99.7
Ном, хэвлэл	23,800,000.00	23,800,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,910,000.00	8,910,000.00	-	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	146,609,870.00	108,095,450.00	38,514,420.00	73.7
Багаж, техник, хэрэгсэл	142,649,870.00	104,135,450.00	38,514,420.00	73.0
Урсгал засвар	3,960,000.00	3,960,000.00	-	100.0
Томилолт, зочны зардал	242,118,700.00	239,528,327.00	2,590,373.00	98.9
Гадаад албан томилолт	162,817,700.00	163,014,186.00	- 196,486.00	100.1
Дотоод албан томилолт	79,301,000.00	76,514,141.00	2,786,859.00	96.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	492,789,200.00	428,644,541.30	64,144,658.70	87.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	477,608,000.00	414,454,700.30	63,153,299.70	86.8

Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	508,641.00	991,359.00	33.9
Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	297,000.00	297,000.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,812,700.00	11,812,700.00	-	100.0
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	49,500.00	49,500.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	229,202,800.00	224,911,791.50	4,291,008.50	98.1
Бараа үйлчилгээний бусад зардал	188,122,800.00	184,187,055.00	3,935,745.00	97.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,080,000.00	40,724,736.50	355,263.50	99.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	243,562,500.00	243,562,500.00	-	100.0
Бусад урсгал шилжүүлэг	243,562,500.00	243,562,500.00	-	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	127,512,500.00	127,512,500.00	-	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал			-	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	116,050,000.00	116,050,000.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,344,833,760.00	2,344,833,760.00	-	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,945,892,000.00	1,945,892,000.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,945,892,000.00	1,945,892,000.00	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	398,941,760.00	398,941,760.00	-	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	-
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	398,941,760.00	398,941,760.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		800,000.00	- 800,000.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	75	75		
Удирдах ажилтан	7	7		
Гүйцэтгэх ажилтан	62	62		
Үйлчлэх ажилтан	6	6		

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Аудитын тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/145/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар			мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 322 дугаар тогтоолын дагуу улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашиг 1,171,317.6 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн,	1,171,317.6	Төлбөрийн акт тогтоосон	ТӨБЗГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Ганбат Ж.Мөнхтүвшин
2	Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гурвалсан гэрээний дагуу байршуулсан 535 түрээслэгчийн 988,039.5 мянган төгрөгийн түрээсийн барьцааны үлдэгдэлтэйгээс 2018.12.31-ны байдлаар 107 түрээслэгчийн 322,297.1 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,	322,297.1	Зөвлөмж өгсөн	ТӨБЗГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Ганбат Ж.Мөнхтүвшин
3	Төрийн өмчийг түрээсээр ашиглаж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудтай хийсэн гурвалсан гэрээний дагуу 2017 онд 876,374.4 мянга, 2018 онд 111,665.1 мянга, нийт 988,039.5 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг Төрийн сан дахь тус байгууллагын "түр" дансанд байршуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	ТӨБЗГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Б.Ганбат Ж.Мөнхтүвшин
	Дүн	1,493,614.7			

